



ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЙЛАН- 2025 ОН

ХЯНАСАН:

Э.ХИШИГДОРЖ, ХСҮТ-ИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ

БЭЛТГЭСЭН:

П.ДУЛАМСҮРЭН, ХСҮТ-ИЙН НИЙГМИЙН
АЖИЛТАН

2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр

АГУУЛГА

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТ	2
1.1 ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ	3
• Төрийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт	3
• ЕБС-ийн сурагчдад зориулсан сургалт.....	3
• Сэтгүүлчдэд зориулан ТББ-тай хамтран хийсэн сургалт	4
• "Сувилагчийн нэг өдөр" зохион байгуулсан өдөрлөг.....	5
1.2 ТӨВИЙН АЖИЛЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ	6
• Шинэ ажилтны сургалт- Байгууллагын соёл	8
• “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023 стандарт” сэдэвт Ёс зүйн сургагч багш нарыг чадавхижуулах сургалт	Error! Bookmark not defined.
• “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023 стандарт” сургалт	Error! Bookmark not defined.
ХОЁР. ХАВДРЫН ДАВАН ТУУЛАГЧДЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР	9
• Хөгжим эмчилгээний Дэлхийн өдөр- 3 дугаар сарын 1	9
• “Хавдрын эсрэг хөгжмөөр нэгдэцгээе” нөлөөллийн уулзалт	10
• Хөгжим эмчилгээний хөтөлбөр.....	12
• Даван туулагчдад зориулсан дэмжих бүлгийн сургалт.....	12
• Эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгчдийн талаарх үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх .	14
• Хавдрын даван туулагчдын санаачлага, оролцоог дэмжих.....	15
ГУРАВ. КАМПАНИТ АЖИЛ.....	15
3.1. ХАВДАРТАЙ ТЭМЦЭХ ДЭЛХИЙН ӨДӨР	16
3.4. “ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ФЕСТИВАЛЬ.....	19
3.6. “ҮЙЛЧҮҮЛЭГЧИЙН ДУУ ХООЛОЙГ СОНСЪЁ” Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдөрт зориулсан өдөрлөг	21
ТАВ. ТЕЛЕВИЗ, РАДИО, СОНИН СЭТГҮҮЛ, НИЙГМИЙН СҮЛЖЭЭГЭЭР МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА ХИЙСЭН БАЙДАЛ.....	Error! Bookmark not defined.
ЗУРГАА. БОЛОВСРУУЛСАН МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛУУД	24

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТ

2025 онд ҮДА-аас олон нийтэд зориулсан сургалт, мэдээлэл сурталчилгааны чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1.1 ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

2025 онд тус албанаас олон нийтэд эрүүл мэндийн боловсрол олгох, хавдрын эрсдэлт хүчин зүйлс, зонхилон тохиолдох хавдруудын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн талаар төрийн 3-н байгууллага, төрийн бус 2 байгууллага, ерөнхий боловсролын 3-н сургууль нийт 7 байгууллагын захиргааны болон үйлчилгээний ажилтан, сэтгүүлч, эмзэг бүлгийн иргэд, ЕБС-ын дунд, ахлах ангийн сурагчид зэрэг 700 гаруй хүнд нийт 10-н удаагийн сургалт зохион байгуулжээ. Үүнд:

- **Төрийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт**

ЗГХЭГ, ЦДБЭЧ, Байгалийн түүхийн музей зэрэг төрийн байгууллагуудын 210 ажилтанд хавдрын эрсдэлт хүчин зүйлс, хавдраас урьдчилан сэргийлэх арга замууд, элэг, ходоод, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, ХПВ-ийн дархлаажуулалтын сэдвээр тус бүр 1 цагийн 3 удаагийн сургалтыг хийв.

- **ЕБС-ийн сурагчдад зориулсан сургалт**

ЕБС-ийн 275 сурагч, 120 эцэг эхийг хамруулан 5-н удаагийг сургалтыг хийсэн байна. Үүнд: 97-р сургуулийн 9-12-р ангийн 75 сурагчид “Тамхи, электрон тамхинаас



татгалзъя” сургалтыг ХСҮТ дээр, Шинэ Монгол сургуулийн 5-р ангийн 60 эрэгтэй, 60 эмэгтэй сурагч, 120 эцэг эхэд “Шилжилтийн нас, охидын болон хөвгүүдийн бэлгийн бойжилт, эрүүл ахуйн асуудлууд” сэдвээр 3-н удаагийн сургалт, ЕБС-ийн 53-р дунд сургуулийн 9-12-р ангийн 80 сурагчид “Бэлгийн

эрүүл мэнд ба эрсдэл” сургалтуудыг тус сургуулиуд дээр нь зохион байгуулсан.

- **Сэтгүүлчдэд зориулан зохион байгуулсан үйл ажиллагаа**

2025 оны 6-р сарын 3-ны өдөр ХСҮТ-ийн өргөтгөлийн 2 давхарт “БИДНИЙ ТҮҮХ – БИДНИЙГ НЭГТГЭНЭ” Хүн төвтэй тусламж үйлчилгээ” төслийн хэрэгжилтийн үр дүнг олон нийт, хамтрагч талуудад танилцуулах мөн уралдаанд оролцсон сэтгүүлчдийн шилдэг бүтээлийн шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг хуваалцах уулзалт амжилттай зохион байгуулагдлаа.

Энэхүү төсөл нь НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж, Зонхилон тохиолдох хорт хавдрууд тэр дундаа вакцинаар сэргийлэх боломжтой умайн хүзүүний болон элэгний хорт хавдраас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн



анхаарлыг хандуулах, шинээр нэвтрүүлсэн ХПВ-ийн эсрэг дархлаажуулалт болон элэгний В вирусын эсрэг нэмэлт дархлаажуулалтын ач холбогдлын талаар сурталчлан таниулах, эрүүл мэндээ хамгаалах зөв мэдлэг ойлголтыг дэмжих зорилготой байлаа.

Тус үйл ажиллагаанд дараах зочид, төлөөлөгчид оролцлоо:

- Монголын хэвлэл мэдээллийн салбараас – сэтгүүлчдийн уралдаанд оролцсон сэтгүүлч, найруулагч, зураглаач нар

- ХСҮТ-ийн захирлын зөвлөл, тасаг албадын эрхлэгч, дарга нар

УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, ЭМ-ийн сайд Т.Мөнхсайхан

ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга Р.Гантуяа ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга Э. Мөнхсүх , АХБ-ны Зөвлөх А.Батбаяр, ЭМЯ-ны Хавдрын тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Г. Хулан, Эрүүл мэндийн мэдээлэл цахим хөгжлийн хэлтсийн дарга Э.Мягмар-Өлзий, ЭМЯ-ны хэвлэл мэдээллийн ажилтан Хэвлэл мэдээллийн ажилтан Ц.Цогзолмаа, ДЭМБ-ийн

Халдварт өвчин болон дархлаажуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн
П.Анузаяа, ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албаны дарга О.Дашпагма нар
оролцсон.

НҮБ-ын Хүүхдийн Сангийн Монгол дах суурин төлөөлөгчийн газраас

1. С. Өлзийсайхан НҮБ-ын ХС-ийн бага насны хүүхдийн хөгжил хариуцсан
мэргэжилтэн
2. Ленин Вонг НҮБ-ын ХС-ийн Эрүүл мэндийн мэргэжилтэн
3. Доржийн Нарангэрэл НҮБ-ын ХС-ийн ХПВ дархлаажуулалтын асуудал хариуцсан
зөвлөх

НҮБ-ын Хүүхдийн Сангийн Бүсийн төлөөлөгчийн GAVI-ийн зөвлөх

1. Tito Rwamushaija, Head of Middle-Income Countries
2. Clovis Nchinjoh Sangwe, Senior Programme Manager, HPV
3. Talia Flores, Programme Manager Тито Рвамушайжа
4. Дунд орлоготой орнуудын хөтөлбөр хариуцсан дарга

Кловис Нчинжох Сангве

5. Хүний папилломавирусын (ХПВ) хөтөлбөрийн ахлах менежер

Талия Флорес

“Бидний түүх биднийг нэгтгэнэ – Хүн төвтэй тусламж үйлчилгээ” энэхүү уралдаан нь
эрүүл мэндийн салбарын хамгийн чухал сэдвийг олон нийтэд таниулах, хүний түүх,
дуу хоолойг түгээхэд үнэтэй хувь нэмэр оруулсан бүтээлүүдээр дүүрэн байлаа.

Тэргүүн байр видео бүтээлийн төрөлд:

•“Хав-дар” асуудал дэвшүүлсэн нэвтрүүлэг – МҮОНТ-ийн сэтгүүлч Г.Бямбалхагва
Сонин, сайтын бүтээлийн төрөлд:

•“Шинжлэх ухаанаас зөрүүдлэхээ больё” – Өнөөдөр сонины сэтгүүлч
Ж.Эрдэнэцэцэг

Тусгай байр “Гепатит вирус ба хорт хавдар” – Tusgal.mn, сэтгүүлч, редактор
Ч.Баяржаргал

•“Эверест намайг дуудаж байх шиг санагддаг” – Gogo.mn, сэтгүүлч Э.Энхмаа

“Бидний түүх биднийг нэгтгэнэ-Хүн төвтэй тусламж үйлчилгээ”

Сэтгүүлчдийн уралдаанд бүтээлээ ирүүлсэн нийт сэтгүүлч найруулагч нартаа
талархал гардуулав. Үүнд:

- “Чимээгүй тахал болсон умайн хүзүүний хорт хавдраар нэг ч хүн нас барахгүй байх боломж бий” – Dobu.mn, сэтгүүлч Б.Хонгорзул
- “Хавдар хаалганы цаана” – MN-25, сэтгүүлч Б.Баттунгалаг, найруулагч Б.Хадбаатар
- “Би өөртөө 20-30 сая төгрөгөөр уушигны хорт хавдар худалдаж авсан” – ETV, сэтгүүлч Э.Энхжаргал
- “Эрт тусмаа эрсдэл бага үүрнэ” – Хөвсгөл аймаг, Мөрөн, Эрх чөлөө сонин, сэтгүүлч Х.Нямжаргал
- “Зөв хооллолт, эрт илрүүлгээр” – Togtool.mn, сэтгүүлч Ц.Чойжамц
- “Хавдраар өвдөх эсэхээ бид өөрсдөө сонгодог” – Eagle.mn, сэтгүүлч О.Даваасүрэн
- “Яагаад хавдартай болов гэж халаглахгүйн тулд” – Gogo.mn, сэтгүүлч, редактор Б.Эрдэнэчимэг
- “Хорт хавдрын нүдэнд үл үзэгдэх эсүүдийг”, “Хавдар яагаад ихсэв”, “Дөнгөж төрсөн нярайд В вирусын вакцин” – Gogo.mn, сэтгүүлч Э.Энхмаа
- “Элэгний хорт хавдар эдгэрдэг” – Unuudur.mn, сэтгүүлч Ч.Болортуяа нарын бүтээлүүд шидлдгээр шалгарсан.



- **“Сувилагчийн нэг өдөр” өдөрлөг зохион байгуулсан:**

Сувилагчдын нийгмийн эрүүл мэндийн оролцоог сайжруулах зорилгоор дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн:

Эхний хагас жилд нийт 5 тасаг Сувилагчийн нэг өдөр өдөрлөг хийсэн. Үүнд: ЕБС-3, Цэцэрлэг-1, ХСҮТ-ийн амбулаторийн үйл ажиллагаанд-1 тус тус явуулсан.

Нийт-216 сурагч, цэцэрлэгийн ахлах бүлгийн 28 хүүхэд, ХСҮТ-ийн шинжилгээ нийт-190 эмчлүүлэгчээс 590 шинжилгээ авч ажилласан байна.

1.2 ТӨВИЙН АЖИЛЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

2025 онд ХСҮТ-ийн ажилчдад зориулсан сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 570 гаруй ажилчдыг хамруулсан байна.

- **“Удирдлагын манлайлал – Хөтөч” сарын аян**

ХСҮТ 2025 оны 6-р сарыг **“Удирдлагын манлайлал – Хөтөч”** аянд зориулж, үйлчлүүлэгчдэд чиглэсэн дараах үйл ажиллагааг зохион байгуулж эхэллээ.

Үйлчлүүлэгчидтэй шууд харилцаж, **түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх соёлыг төлөвшүүлэх**, санал хүсэлт сонсох ажлыг эхлүүлэв.

“Өглөөний уулзах цаг”-ийг Лхагва гариг бүрийн 07:30–08:30 цагт тогтмол зохион байгуулж байна.

Эхний уулзалт нийт **14 үйлчлүүлэгч** оролцож, санал хүсэлтээ илэрхийлэв. Уулзалт үргэлжилж байна.

- Төвийн нийт ажилчид болон үйлчлүүлэгчдэд зориулан сэтгэл хөдлөлөө хэрхэн удирдах, сэтгэл хөдлөлөө зөв удирдсанаар сэтгэцийн эрүүл мэндэд ямар эерэг үр дагаврууд гарах талаар сургалтыг зочин илтгэгчээр оруулсан.



ХСҮТ-ийн Үйлчлүүлэгчийг дэмжих албанаас эмч, сувилагч нар болон эмнэлгийн ажилчдад зориулсан ажлын байрны стрессийг бууруулах, анхаарал төвлөрлийг сайжруулах талаар мэдлэг олгох, эерэг хандлага төлөвшүүлэх "Танин мэдэхүйд суурилсан энэрэх сэтгэлийг хөгжүүлэх нь" (CBCT) сэдэвт 8 модуль, 16 цагийн

сургалтын хөтөлбөрийг сургагч багш нартай хамтран 1-р сарын 14-өөс хэрэгжүүлж, нийт 454 ажилтныг хамруулан амжилттай өндөрлөлөө.



ХОЁР. ХАВДРЫН ДАВАН ТУУЛАГЧДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- **Хөгжим эмчилгээний Дэлхийн өдөр- 3 дугаар сарын 1**

Тус төв нь 2022 оноос эхлэн Хөгжим эмчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаатай холбогдуулан жил бүрийн 3-р сарын 1 буюу “Дэлхийн хөгжим эмчилгээний өдөр”-ийг 3 дах жилдээ тэмдэглэн өнгөрүүллээ. Хавдрын даван туулагчдад итгэл найдвар, урам зориг өгөх, урлагаар эрүүл мэндийг дэмжих зорилгын хүрээнд тухайн өдөрт зориулан тусгай удирдамж, хөтөлбөр боловсруулан бүтэн өдрийн арга хэмжээг зохион байгуулдаг юм. ХӨГЖИМ БИДНИЙГ НЭГТГЭНЭ-2025” хамтрагч талуудын зөвлөлдөх уулзалт боллоо.

Жил бүр 3-р сарын 1 бол Дэлхийн хөгжмийн эмчилгээний өдөр юм. Энэ өдөр дэлхий нийтээр хөгжим эмчилгээний ач холбогдол, хүний эрүүл мэндэд үзүүлэх сайн нөлөөг олон нийтэд таниулдаг. Өнөө үед хүний эрүүл мэндийн асуудалд цогцоор нь хандаж, эмийн, мэс заслын, нөхөн сэргээх эмчилгээнүүдээс гадна нийгмийн, сэтгэл санааны тусламж үйлчилгээг хамтад нь үзүүлдэг хөгжлийн чиг хандлага улам бүр хүчтэй түрэн хөгжиж байна.

Хавдар судлалын үндэсний төв нь 2022 онд Дэлхийн хөгжим эмчилгээний өдөр буюу 3-р сарын 1-нд хөгжим эмчилгээний хөтөлбөрөө эхлүүлсэн билээ. Энэхүү хөтөлбөр нь 7 хоногт 1 удаа, 1 цаг үргэлжилдэг бөгөөд өнөөг хүртэлх хугацаанд мэргэжлийн урлагийн 20 орчим байгууллага, хамтлаг, студийн 500 гаруй уран бүтээлчид дэмжин оролцож 156 удаагийн үйл ажиллагаа амжилтай зохион байгуулжээ

Энэ өдөр ХСҮТ-д 10.00-14.00 цаг хүртэл ДБЭТ, Улаанбаатар театр, Үндэсний урлагийн их театр, СУИС-ХУС, МУ-ын Консерватори, МУ-ын Филармоний хөгжимчид, уран бүтээлчид ирж дэлхийн болон үндэсний сонгодог бүтээлүүдээс тоглолт хийлээ.

- **“Хавдрын эсрэг хөгжмөөр нэгдэцгээе” нөлөөллийн уулзалт**

Мөн уг хөтөлбөрийг 2023 онд үргэлжлүүлэн хөгжүүлэх талаар хамтрагч талуудын зөвлөлдөх уулзалт ярилцлага боллоо.



Уулзалтад Соёлын яамны Хөгжмийн урлагийн бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Амарсанаа, ЗГХА-Соёл урлагийн газрын Хөгжмийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн О.Энхмаа, СУИС-ийн уран бүтээл, хамтын

ажиллагааны газрын дарга, доктор, дэд профессор Э.Зулцэцэг, тус газрын мэргэжилтэн А.Ууганзаяа, СУИС-ийн Хөгжим урлагийн сургуулийн захирал, дэд профессор Г.Ганцэцэг, МУ-ын Консерваторийн уран бүтээл, маркетингийн албаны дарга М.Мөнхсайхан, МУ-ын Филармонийн захирал С.Баттулга, Улаанбаатар театрын дарга Ю.Гэрэлбаатар, Үндэсний урлагийн их театрын менежер, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын Захиргаа үзвэр үйлчилгээний хэлтсийн дарга д/х А.Дондов, Монос эмийн үйлдвэрийн гүйцэтгэх захирал М.Одгэрэл, НЭМҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Оюун-Эрдэнэ болон ХСҮТ-ийн ерөнхий захирал Н.Эрдэнэхүү, эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд захирал С.Хүрэлсүх, ХСҮТ-ийн зөвлөх, хүний гавъяат эмч Г.Одонтуяа, Хүний нөөц хөгжлийн албаны дарга Д.Мөнхтуяа, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албаны дарга Б.Баасанжав, Санхүү эдийн засгийн албаны дарга Б.Дэнсмаа, Хавдрын бүртгэл тандалт, эрт илрүүлгийн албаны дарга Т.Ундармаа, Нийгмийн эрүүл мэнд, төлөвлөлт сургалтын албаны дарга Ц.Бадамсүрэн, Үйлчлүүлэгчийг дэмжих албаны дарга Л.Энхээ нар оролцлоо. Уулзалтын үеэр хавдрын өвчлөлийн төлөв байдал, хорт хавдар нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, хавдрын даван туулагчдыг дэмжих хөтөлбөрүүд болон хөгжим өөрөө эмчилгээ болох тухай илтгэлүүдийг танилцуулж цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцон ярилцсан юм.

СУИС-ийн ХУС-ийн захирал Г.Ганцэцэг захирал “Хүн өөрөө хөгжим юм. Хөгжим бол эмийн бус эмчилгээ гэдгийг шинжлэх ухаан аль хэдийн нотлосон. Тиймээс ХСҮТ-өөс хэрэгжүүлж буй энэ хөтөлбөр туйлын чухал, үр дүнтэй учраас цаашид үргэлжлүүлэх зайлшгүй шаардлагатай” гэдгийг онцлон хэлж, эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдийн сайн сайхны төлөө олон чухал санаануудыг бодит ажил болгохын төлөө хамтран ажиллахаа илэрхийлсэн.

- **Хөгжим эмчилгээний хөтөлбөр**

ХСҮТ 2021 оны 12-р сард үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхимдаа төгөлдөр хуур бүхий орчинтой болсноор, 2022 оны 3-р сарын 1-ээс хойш өнөөг хүртэл “Хөгжим эмчилгээ” хөтөлбөрийг үйлчлүүлэгчид, эмчлүүлэгчид, хавдрын даван туулагчдад зориулан хэрэгжүүлж байна. Долоо хоног бүрийн Лхагва гариг бүрийн 11.00-12.00



цагт болдог хөгжим эмчилгээний хөтөлбөрийг дэмжин 2023 онд СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургууль, МУ-ын Филармони, Үндэсний урлагийн их театр, Улаанбаатар театр, ХЦДБЧ, ЦДБЭЧ, төгөлдөр хуурын

сургалтын төв, ЕБС-ийн сурагчдын хөгжмийн чуулга, соло уран бүтээлчид, даван туулагчид зэрэг 150 гаруй хөгжимчид, дуучид оролцож 40 удаагийн хөгжим эмчилгээг зохион байгууллаа. Манай хөтөлбөрт мэргэжлийн урлагийн байгууллагуудаас гадна олны танил уран бүтээлчид биднийг дэмжин оролцож байна.

ХСҮТ-ийн зүгээс хөгжим эмчилгээний хөтөлбөрийг дэмжин оролцсон уран бүтээлчдэд ХСҮТ-ийн ерөнхий захирлын “Талархал”-ийг гардуулж, тоглолтыг лайваар дамжуулах, төвийн пэйж хуудсанд мэдээлэл оруулан нийтэд түгээх зэргээр уран бүтээлчдээ урамшуулан дэмждэг юм.

- **Даван туулагчдад зориулсан дэмжих бүлгийн сургалт**

- ХСҮТ-ийн ҮДА-ны нийгмийн ажилтан, хоол зүйч, сэтгэл зүйч нар төвийн үйлчлүүлэгч болон, хэвтэн эмчлүүлэгч, хяналтын өвчтнүүдэд зориулан хавдрын эмчилгээ, хэвтэх үеийн болон гарсны дараах үеийн хооллолт, нийгмийн халамж тэтгэмж, сэтгэл зүйн тааггүй байдлаа даван туулах

сэдвүүдээр сургалтыг зохион байгуулж байна. Элэг, элэг шилжүүлэн суулгуулсан хүлээн авагч болон донорууд, ходоод, умайн хүзүү, хөхний хавдрын даван туулагчид, асран халамжлагчдад зориулсан сэдэвчилсэн сургалтыг сард 1 удаа нийт 10-н удаа хийж нийт 208 хүнийг хамруулжээ.



- Жил бүрийн 10 дугаар сарыг олон улсад хөхний хорт хавдрыг таниулах, эрт илрүүлгийн мэдээлэл түгээх сар болгон өрнүүлдэг. 2024 оны байдлаар 77 хүн тутмын 1, 42 эмэгтэй тутмын 1 нь хөхний хорт хавдарт өртөх эрсдэлтэй байв. 2024 онд хөхний хавдарт өртсөн дундаж насны хувьд эмэгтэйчүүдэд 54 нас байна. Хөхний хорт хавдрын тархалтыг Монгол улсын газар зүйн бүс нутгаар харьцуулан үзэхэд Хойд, Төвийн бүс болон Улаанбаатар хот улсын дунджаас өндөр, Зүүн, Баруун, Говийн, Хангайн бүсэд өвчлөл бага үзүүлэлттэй байна.

Энэ хүрээнд ХСҮТ-ийн Үйлчлүүлэгчийг дэмжих албанаас эмчлүүлэгчид, асран халамжлагчдад үйлчлүүлэгчдэд зориулан “Wear pink, Save lives” сэдэвт хавдрыг



даван туулагчдын дэмжих уулзалтыг **Miss World - Mongolia**-тай хамтран зохион байгууллаа. Уулзалтыг ХСҮТ-ийн Ерөнхий захирал Ц.Батболд болон Азиан Фючир ХХК-ийн захирал Г.Уянгалянхуа нар нээж үг хэлсэн бөгөөд ХСҮТ-ийн Эмчилгээ эрхэлсэн орлогч захирал

С.Хүрэлсүх, ХСҮТ-ийн Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал Э.Хишигдорж нар болон тасаг, албадын дарга, эрхлэгч нар оролцлоо.

Уулзалтад ХСҮТ-д хэвтэн эмчлүүлэгч, сахиур, хяналтын өвчтөн, эмч ажилтнууд зэрэг 100 гаруй хүн оролцсон дэмжих уулзалтад хөхний хавдрыг даван туулагч, дэлхийн дээвэр Эверестийн оргилд амжилттай оргилдсон уулчин, Монгол Улсын зөвлөх инженер Б.Батхишиг, Наран Ижий ТББ-ын тэргүүн, хөхний хавдрын даван туулагч Ш.Ариунаа нар зочин илтгэгчээр оролцож өөрсдийн туршлагаасаа хуваалцсан юм.

Мөн **Miss World - Mongolia**-ийн Монгол дахь эрхийг эзэмшигч, Азиан Фючир ХХК-ийн захирал Г.Уянгалянхуа болон Miss World Mongolia 2026 оны тэмцээний үндэсний ялагч Б.Энхтуул, Miss World Mongolia 2025 оны тэмцээний үндэсний ялагч Б.Эрдэнэсүвд нар хүрэлцэн ирж хөхний хавдрын даван туулагчдад урам өглөө.

Зочин илтгэгчдийн хавдрыг даван туулж буй өөрсдийн түүх, туршлага, хөгжилтэй хэрнээ ухаарал бүхий чин сэтгэлийн яриа нь уулзалтад оролцогчдод итгэл найдвар, урам зориг өгсөн, халуун дулаахан уулзалт боллоо.

Мөн ХСҮТ-ийн хөхний төвийн эмч Н.Цэнгэл хөхний тусламж үйлчилгээний талаар, ХСҮТ-ийн Сэргээн засах тасгийн хөдөлгөөн засалч Ц.Цолмонбаяр хөхний хавдрын үеийн сэргээн засах эмчилгээний талаар мөн Нийгэм сэтгэл судлалын дээд сургуулийн сэтгэл зүйн багш нар хүрэлцэн ирж даван туулагчдад зориулан олон төрлийн сонирхолтой лекц, дасгалуудыг удирдаж явууллаа.

- **Эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгчдийн талаарх үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх**

ҮДА-аас АНУ-ын эмнэлгүүдэд хийгддэг үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх асуумжийг ашиглан энгийн, хялбар асуумжаар амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэгчдээс үйлчилгээ үзүүлэгчдийг үнэлэх судалгааг хагас жилээр хийж үр дүнг танилцуулсан.

Түүнчлэн асран халамжлагчийн ачааллыг үнэлэх судалгааг хийж үр дүнг “Хавдрын тулгамдсан асуудал-2025” эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн.

Хөгжим эмчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг үнэлэх судалгааг хийж үр дүнг албаны хурлаар хэлэлцэн ажлаа сайжруулахад ашиглаж байна.

- **Хавдрын даван туулагчдын санаачлага, оролцоог дэмжих**

ХСҮТ-өөс хавдрын даван туулагчдын санаачлага, оролцоог дэмжих хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал, Наран ижий заяа ТББ-аас зохион байгуулдаг “Боломж үргэлж байдаг” цуврал сургалт, уулзалтуудыг дэмжин төвийн удирдлага, тасаг албадын эрхлэгч, дарга, эмч мэргэжилтнүүд оролцон хамтран ажиллалаа. 2025 онд тус ТББ-ын 5 удаагийн уулзалт арга хэмжээнд очиж оролцон даван туулагчдын санал бодлыг сонсон ярилцахын зэрэгцээ мэргэжлийн зөвлөгөө, сургалтуудаар дэмжин ажиллалаа. Даван туулагчдын зүгээс эрт илрүүлэг, даатгалд хамруулвал зохих зарим эмүүд, нийгмийн дэмжлэг, хүний эрхийн чиглэлээр олон чухал санаануудыг хэлж байлаа.

Түүнчлэн хавдрын даван туулагчдын дуу хоолойг нийгэмд түгээх, тэдний сайн дурын ажил, оролцоо, санаачлагын талаар хэвлэл мэдээллээр сурталчлах зорилгоор МҮОНТ, МҮОНР, ТВ-25, С1, Ийгл ТВ, Өнөөдөр сонин, GoGo.mn сайт болон сусад сайтуудын нэвтрүүлэг, ярилцлага зэргийг 10 гаруй удаа хийгдсэн байна.

Сэргээн засах тасагтай хамтран **“Мэс заслын өмнөх бэлтгэл”** сэдвээр **эмчлүүлэгчдэд зориулсан сургалт** зохион байгуулж, хагалгааны өмнөх сэтгэлзүйн болон бие махбодын бэлтгэлийг сайжруулах мэдлэг олголоо.

- ЭЦНБМТ хэвтэн эмчлүүлж буй хүмүүст зориулсан **“Айдас, түгшүүрээ хэрхэн зохицуулж сурах вэ?”** сэдэвт **сэтгэл зүйн сургалт** зохион байгуулсан

ГУРАВ. КАМПАНИТ АЖИЛ

2025 онд 6-н удаагийн олон нийтэд зориулсан кампанит ажил зохион байгуулжээ.

3.1. ХАВДАРТАЙ ТЭМЦЭХ ДЭЛХИЙН ӨДӨР

Хорт хавдрын эсрэг дуу хоолойгоо нэгтгэх, олон нийтийн анхаарлыг хандуулах, үнэн, бодитой мэдээлэл түгээх, хорт хавдраас сэргийлэх, эрт илрүүлэгт хамрагдахын ач холбогдлыг сурталчлан ойлгуулах зорилгоор жил бүрийн 2 дугаар 4-нд “Хавдрын эсрэг Дэлхийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай.

Энэ өдрийг тэмдэглэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Хавдрын эсрэг Дэлхийн өдрийн хүрээнд “Морфиус Медиа” ХХК-тай хамтран “Тэгш боломж-үл ялгаварлал/Дуу хоолойгоо нэгтгэе, үйлдэл хийе” уриатай 60 секундын видео шторкийг олны танил жүжигчдийг оролцуулан хийж МҮОНТ, UBS, TV58 Eagle TV, төвийн пэйж хуудас болон аймаг, дүүргүүдийн хавдар судлаач эмч нарт илгээн үндэсний хэмжээнд түгээсэн.



Мөн уг өдөрт зориулан ДЭМБ-аас гаргасан 5-н төрлийн постерыг орчуулан монголоор бэлтгэж төвийн пэйж хуудас, олон нийтийн сүлжээгээр түгээж, ухуулга нөлөөлөлд ашиглалаа.



Олон Улсын Хавдрын Хяналтын Холбооноос (UICC) анх санаачилан жил бүрийн 2-р сарын 4-ыг хавдрын эсрэг анхаарал хандуулах Дэлхийн өдөр хэмээн зарласан бөгөөд манай улс уг өдрийг 2007 оноос эхлэн тэмдэглэж байна.

Хорт хавдраас сэргийлэх, хянах, хор хөнөөлийг бууруулахад дэлхийн улс орнуудын засгийн газрын хүчин чармайлтыг сайжруулах, нийгмийн бүх салбар, иргэд, олон нийтийн үүрэг оролцоо, санаачлагыг нэмэгдүүлэх, хавдраар өвдсөн хэн бүхэн хаана



амьдардаг, хэн байхаас үл хамааран шаардлагатай тусламж үйлчилгээгээ сэтгэл ханамжтай авдаг байх боломжийн төлөө дуу хоолойгоо нэгтгэхэд энэ өдрийн зорилго оршино.

4 Бид 2025 оны хавдрын эсрэг Дэлхийн өдрийг “Бидний түүх-Биднийг нэгтгэнэ. Хүн төвтэй тусламж үйлчилгээ” уриан дор

тэмдэглэж байна.

Хавдраар өвдсөн шалтгаан, хавдрын түүх нь хүн бүрд өөр, хүн бүр ялгаатай, өвөрмөц ч гэсэн өөрт шаардлагатай тусламж үйлчилгээгээ авах, хавдрыг даван туулах, эрүүл чанартай амьдрах хүсэл, зорилгоороо нэгдэх, хүн төвтэй, хүнд ээлтэй тусламж үйлчилгээг хөгжүүлэхийг дэлхий нийтэд уриалж байгаа билээ.

ХСҮТ-өөс энэ өдрийн хүрээнд сэтгүүлчдэд зориулсан сургалтыг зохион байгуулж МҮОНТ, UBS, ETV, НДМонгол, ТВ9 зэрэг 8 телевиз, МҮОНР, 6 сайтын 20 сэтгүүлч оролцож, хорт хавдрын өвчлөл нас баралтын өнөөгийн байдал, тусламж

үйлчилгээний ахиц ололт, хавдраас сэргийлэх ухуулга нөлөөллийн үйл



ажиллагаанд сэтгүүлчдийн үүрэг оролцоо, элэгний болон умайн хүзүүний хавдрын анхдагч сэргийлэлт болох дархлаажуулалтын үр нөлөө, ач холбогдол зэрэг олон сэдвээр мэдээлэл авсан юм.

Сургалтын нээлтэд УИХ-ын гишүүн, ХСҮТ-ийн зөвлөх эмч Ж.Чинбүрэн, НҮБ-

ын Хүүхдийн сангийн Монгол дах суурин төлөөлөгч Эваристе Коуасси-Комлан НҮБ-ын Хүүхдийн сангийн ахлах мэргэжилтэн Ч.Батаа, МУ-ын Хүний гавъяат эмч, НҮБ-ын Хүүхдийн сангийн дархлаажуулалтын зөвлөх Д.Нарангэрэл, НЭМҮТ-ийн ЭМДМА-ны дарга С.Гэрэлмаа, ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албаны дарга О.Дашпагма, дархлаажуулалтын эмч нар зэрэг хүндэт зочдоос гадна ХСҮТ-ийн ерөнхий захирал Н.Эрдэнэхүү, Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал Ц.Уранчимэг тус төвийн тасаг, албадын эрхлэгч, дарга нийт 50 гаруй хүн оролцож мэдээлэл хуваалцан ярилцлаа.

Хорт хавдрын үзүүлэлт-2024-өөс:

Монгол улсын хүн амын дунд 2024 онд 8169 хорт хавдрын шинэ өвчлөл бүртгэгдсэн нь өнгөрсөн оныхоос 925 тохиолдлоор, 4755 хүн энэ өвчний улмаас нас барсан нь өнгөрсөн оны үеийнхээс 199 тохиолдлоор тус тус нэмэгджээ.

Хорт хавдрын өвчлөлийн бүтцэд элэг (28.9%), ходоод (16.2%), уушиг гуурсан хоолой (6.7%), умайн хүзүү (6.4%), бүдүүн, шулуун гэдэсний (5.0%) хорт хавдрууд нийт хорт хавдрын өвчлөлийн 63.2 хувийг эзэлж байна.

Шинээр оношлогдсон нийт хавдрын 36.6% нь эрт үе шатандаа, 64.4% нь хожуу үе шатандаа оношлогджээ.

Хорт хавдрын шалтгаант нас баралтын бүтцэд элэг, ходоодны хавдрууд нийт нас баралтын 52.2%-ийг эзэлж байна.

Хавдрын асуудалд олон нийтийн анхаарал хандуулах, хүн бүрийн хүчин чармайлтыг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагуудын үүрэг оролцоо нэн чухал билээ.

Энэ хүрээнд ХСҮТ-өөс сэтгүүлчдийн дунд бүтээлийн уралдааныг зарласан.

Мисс Ворлд Монголиа-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах ёслол

Хавдар Судлалын Үндэсний Төвийн ХӨХНИЙ ТӨВД иж бүрэн засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх хүмүүнлэгийн төслийн санамж бичиг байгуулах ёслол



болж Miss World тэмцээний Монгол дахь эрх эзэмшигч, "Азиан Фючир" ХХК-ийн захирал Д.Уянгалянхуа болон Хавдар Судлалын Үндэсний Төвийн захирал Ц.Батболд нар хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.

10-р сар Хөхний хавдрын эсрэг анхаарал хандуулах сар бөгөөд

"Дэлхийн Мисс" тэмцээний оролцогчид "Хөхөө хайрлая хамгаалъя, халамжилъя" уриан дор охид бүсгүйчүүдийг эрт илрүүлэгт орохыг уриалахын зэрэгцээ Хүмүүнлэг үйлсийн хүрээнд Дэлхийн стандартад нийцсэн Хөхний төв байгуулах үйлсийг зохион байгуулж байгаа юм.



3.4. “ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ФЕСТИВАЛЬ

15 жилийн ойгоо сурталчлан “Хавдрын эсрэг үндэсний аян”-ийн хамтрагч талуудын байгууллагууд “Улаанбаатар марафон 2025”-ийн 5 км-ийн зайн гүйлтэд нэг баг болон оролцлоо.



Хавдар судлалын үндэсний төвийн нийт 40 ажилтан. Мөн МҮОНРТ, ХААН Банкнаас нийт 40 ажилтан тус гүйлтэд оролцож, Нийт 90 гаруй хүн 5 км-ийн зайн гүйлтэнд амжилттай бариалсан бөгөөд ХСҮТ-ийн 10 гаруй ажилтан нь урт зайн буюу 10 км болон хагас марафон (21 км)-д амжилттай оролцлоо.

Марафоны үеэр “Хавдрын эсрэг үндэсний аян”-ийн сурталчилгааны асар ажиллаж, иргэдэд хорт хавдраас урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлгийн ач холбогдлын талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн иргэдийн биеийн жин, артерийн даралтыг хэмжих үйлчилгээ үзүүлж, нийт 160 гаруй хүн хамрагдсан байна.



“Хавдрын эсрэг үндэсний аян” 15 жилийн ой “Улаанбаатар марафон 2025”-т амжилттай оролцлоо.

2011 онд Хавдар судлалын үндэсний төв, Хаан Банк, МҮОНРТ-тэй хамтран “Хавдрын эсрэг үндэсний аян” 15 жилдээ амжилттай хэрэгжиж байна.

Энэ хугацаанд уг аян Монгол орныг дөрвөн удаа бүтэн тойрон, 133 мянган иргэнийг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээнд хамруулж, 660 гаруй хорт хавдрыг оношлон, 558

гаруй мэс засал хийж, орон нутгийн иргэдэд хавдрын тусламж, үйлчилгээг газар дээр нь үзүүллээ.

8000 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг “Хорт хавдрын тулгамдсан асуудал, орчин үеийн оношлогоо, эмчилгээ” сэдвээр чадавхжуулах сургалтад хамруулсан.

ХААН Банкны орон нутгийн салбарын 2800 гаруй ажилтан сайн дурын идэвхтнээр бэлтгэгдсэн нь уг аяныг үр дүнтэй, хүрээ өргөнтэй хэрэгжихэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

“Хавдрын эсрэг үндэсний аян”-ийн 15 жилийн түүх бол төр, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын амжилттай хамтын ажиллагааны тод жишээ бөгөөд энэхүү түншлэл цаашид ч олон хүний амь насыг аврах, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлсэд чухал хувь нэмэр оруулсаар байх болно.

3.6. “ҮЙЛЧҮҮЛЭГЧИЙН ДУУ ХООЛОЙГ СОНСЪЁ” Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдөрт зориулсан өдөрлөг

ДЭМБ-ийн ассамблейн чуулганаас 2019 оноос эхлэн жил бүрийн 9-р сарын 17-ныг Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдөр” болгон зарласан билээ.

Энэ жилийн өдрийг “Хүүхэд бүрт эрүүл мэндийн аюулгүй, чанартай тусламж үйлчилгээг хүргэе” уриан дор тэмдэглэн өнгөрүүлээ.



ХСҮТ-өөс энэхүү өдрийн хүрээнд туяа эмчилгээний тасагт эмчлүүлж буй хүүхдүүдийн асран халамжлагчид, мөн тус эмнэлгээр үйлчлүүлэгчдэд гарын ариун цэвэр, хүүхдийн хооллолт, дэлгэцийн зохистой хэрэглээ, хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн хор хөнөөл,

урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг зэрэг сэдвээр мэдээлэл түгээж, хүүхдийн аюулгүй байдлыг хангахад олон нийтийн анхаарал хандуулахад чиглэсэн ажлуудыг зохион байгууллаа

“Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал” гэдэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүхий л явц нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангасан байх, оролцогч 2 тал болох эмнэлгийн ажилтан, үйлчлүүлэгч 2-уулаа эрүүл мэндийн эрсдэлд өртөхгүй байх боломж юм.

Тиймээс эмнэлгийн тусламж үйлчилгээний явцад гарч болзошгүй эрсдлүүдээс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг сайжруулахад иргэд хэрхэн оролцож болох талаар мэдээ мэдээллүүдийг түгээх, сурталчлан таниулах зорилгоор “ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН” өдрийг ХСҮТ-ийн Үйлчлүүлэгчийг дэмжих алба, ЭМТҮЧАБА, Сувилахуйн алба,




Эмчилгээний хоол шим тэжээлийн тасаг, Эм зүйн алба, Сэргээн засах тусламж үйлчилгээний тасаг, Халдварын хяналт, сэргийлэлтийн алба, Мэдээлэл технологийн албад хамтран зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр дараах үйл

ажиллагаануудыг хэрэгжүүлэв. Үүнд:

- Өртөөчилсөн мэдээлэл сурталчилгааны 3-н хэсгийг төвийн цахим бүртгэл, өргөтгөлий хэсэг, яаралтай тусламжийн хэсгийн үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхимуудад байршуулан үйлчлүүлэгчдийг халуун шүүс, аарцаар угтан дайлж, гарын ариутгал, эмийн зохистой хэрэглээ, сувилахуйн тусламж, хоол зүй, сэтгэл зүй, хавдрыг даван туулахуй сэдвээр зөвлөгөө мэдээлэл өгч, санамж гарын авлага түгээлээ. Эдгээр үйл ажиллагаанд төвийн амбулаториор үйлчлүүлэгчид өргөн оролцсон.

ХСҮТ-ийн нүүр ном

Мэдээллийн тоо: Нүүр номонд нийт 700 гаруй удаа мэдээ байршуулж, баяжуулан шинэчилсэн байна.



Хандагчид: 2025 онд төвийн үйл ажиллагаа, тусламж үйлчилгээ, хавдрын эрсдэлт хүчин зүйлс, зонхилон тохиолдох хавдруудын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, эмч ажилчдын нийгмийн асуудал, ажлын байрны зар, эрдэм шинжилгээ судалга зэрэг сэдвүүдээр 600 гаруй мэдээ байршуулж хандагчдын тоо 77000 гаруйд хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 5000 гаруйгаар нэмэгджээ

Хэвлэл мэдээлэл

Хавдрын тусламж үйлчилгээ, төвийн үйл ажиллагаа, эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаа, хавдраас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн 80 орчим хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр давхардсан тоогоор нийтдээ 800 гаруй мэдээлэл түгээсэн байна. Үүнд:

- Сонин хэвлэлээр дамжуулан 15 удаагийн мэдээ, сурвалжлага
- МҮНОТВ, UBS, ТВ-5, ТВ-9, ТВ-25, Өлзий ТВ, Ийгл ТВ, Тэнгэр Тв, С1 ТВ, ETV, HDMongol TV, Малчин ТВ, NTV, Eagle TV зэрэг сувгуудаар 150 орчим удаагийн мэдээ мэдээлэл
- Нийгмийн сүлжээ, мэдээллийн сайтаар 200 орчим удаагийн мэдээлэл, ярилцлага

- Монголын Үндэсний Радио, MGLRadio-Дэлхийн Монголчууд ФМ-ээр 50 удаагийн ярилцлага, мэдээ, мэдээлэл тус тус түгээгджээ.

Эмчийн лайв зөвлөгөө:

“Хорт хавдрын мэдээллийн сар”-ын хүрээнд умайн хүзүү, ходоод, улаан хоолой, бүдүүн шулуун гэдэс, хөх, уушигны хорт хавдруудаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ач холбогдол, стомын үеийн арчилгаа зэрэг сэдвүүдээр 7 удаагийн “LIVE” нэвтрүүлэг бэлтгэн, өөрийн цахим хуудсаараа дамжуулан 5 дах жилдээ хүргэлээ. Тус “LIVE зөвлөгөө”-г МҮОНТ болон бусад мэдээллийн сайтууд шууд хуваалцан түгээж байна.

ЗУРГАА. БОЛОВСРУУЛСАН МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛУУД

- Хавдрын үеийн шим тэжээл гарын авлагыг боловсруулж, төвийн пейж хуудсанд байршуулсан. Мөн үйлчлүүлэгч түүний ар гэрт унших зориулалтаар ашиглуулж байна. Хавдрын шим тэжээл бүхий л шатны эрүүл мэндийн байгууллагын



мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлагыг боловсруулж 200 ширхэгийг хэвлүүлсэн.

- Зонхиолон тохиолдох 7-н байрлалын хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ач холбогдлын талаар санамж, Умайн хүзүүний хорт хавдаргүй ирээдүй гарын авлага, Бидний түүх, биднийг нэгтгэнэ- хорт хавдрын талаар сэтгүүлчдийн бичсэн бүтээлийн эмхэтгэл, Хавдартай өвчтөний өврийн дэвтэр, Хавдрын мэдээллийн саруудын хуанли постер шинэчлэн боловсруулж 500 ш нийт 2500 ш материал хэвлүүлэн аймаг, дүүрэг болон ХСҮТ-ийн эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдэд түгээсэн.